

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТ


Хэлэлцүүлэгт зориулсан тойм

Судлаач: Д. Баярмаа

Энэхүү танилцуулга нь Нээлттэй Нийгмийн Хүрээлэнгийн албан ёсны байр суурь биш бөгөөд гагцхүү хувь судлаачдын байр суурийг илтгэнэ



Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт **9.6 их наяд ₮**-ийн төсөвт өртөгтэй, **3.3 их наяд ₮**-ийн санхүүжих дүнтэй **579** хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгажээ.



Шилжих төсөл, арга хэмжээ



Шилжих төсөл,
арга хэмжээний тоо

430



Нийт төсөвт өртөг

7.38 их наяд ₮



2026 онд санхүүжих дүн

2.18 их наяд ₮

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ



Шинээр хэрэгжих төсөл,
арга хэмжээний тоо

149



Нийт төсөвт өртөг

2.26 их наяд ₮




2026 онд санхүүжих дүн

1.09 их наяд ₮

2026 онд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг шилжих төсөл, арга хэмжээтэй харьцуулвал нийт тоо 2.8 дахин, нийт төсөвт өртөг 3.3 дахин, санхүүжих дүн 2 дахин бага байна.


Монгол Улсын 2020-2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн (тэрбум ₮)



Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо өмнөх 2025 онтой харьцуулахад 43-аар өсч, нийт төсөвт өртөг 135 тэрбум ₮-өөр буурч, тухайн онд санхүүжих дүн 99.8 тэрбум ₮-өөр өссөн байна. Харин 2024 оны сонгуулийн жилтэй харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 4.7 дахин, нийт төсөвт өртөг 2.6 дахин, тухайн онд санхүүжих дүн 2.1 дахин буурчээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар

Нийт төсөвт өртгийн **69.7** хувийг барилга, байгууламж, **23.1** хувийг тоног, төхөөрөмж, **3.8** хувийг их засвар, **4** хувийг ТЭЗҮ, **1.1** хувийг цахим систем эзэлж байна.



■ Барилга байгууламж ■ Тоног төхөөрөмж
■ Их засвар, ТЭЗҮ, Цахим систем



Барилга, байгууламж (71)

Нийт төсөвт өртөг: 1,573.7 тэрбум ₮ (69.7%)
2026 онд санхүүжих дүн: 507.1 тэрбум ₮ (46.7%)



Тоног, төхөөрөмж (63)

Нийт төсөвт өртөг: 521.4 тэрбум ₮ (23.1%)
2026 онд санхүүжих дүн: 482.1 тэрбум ₮ (44.4%)



Их засвар (9)

Нийт төсөвт өртөг: 77.4 тэрбум ₮ (3.4%)
2026 онд санхүүжих дүн: 41.2 тэрбум ₮ (3.8%)



ТЭЗҮ(2)

Нийт төсөвт өртөг: 52.2 тэрбум ₮ (2.3%)
2026 онд санхүүжих дүн: 43.6 тэрбум ₮ (4%)



Цахим систем (4)

Нийт төсөвт өртөг: 32 тэрбум ₮ (1.4%)
2026 онд санхүүжих дүн: 11.4 тэрбум ₮ (1.1%)

Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих барилга, байгууламжийн төрөл (тэрбум ₮)

Төрөл	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төрөл	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Авто зам	4	379.3	73.8	Спорт заалны барилга	6	16.3	7.3
Эмнэлгийн барилга	3	282.1	52.3	Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц	1	14.4	4.3
Хурал зохион байгуулахтай холбоотой барилга, байгууламж	1	150	150	Цэцэрлэгийн барилга	2	10.8	4.8
Цахилгаан дамжуулах агаарын шугам	2	118.2	19.3	Үйлдвэрийн цэвэрлэх байгууламж	1	9.4	2.8
Цахилгаан, дулаан хангамж	1	78.1	23.4	Аялал жуулчлал, спорт цогцолборын барилга	1	8.4	3.8
Тусгай зориулалтын барилга, байгууламж	3	66.4	24.9	Цэвэр усны шугам сүлжээ	3	8.2	3.7
Дулааны станцын хэлхээ, дэд бүтэц	2	54.7	9	Инженерийн шугам сүлжээ	2	7.1	3.2
Дулааны шугамын өртгөтгөл, шинэчлэл	1	53.7	16.1	Цагдаагийн газрын барилга	2	6.8	3.1
Сургуулийн өргөтгөлийн барилга	3	47.7	15.3	Спорт цогцолборын барилга	1	6.7	2
Гал түймэр унтраах, аврах ангийн барилга	4	31.2	10.3	Албан хаагчдын орон сууцны барилга	1	6.5	2
Гүүр	3	30.8	9.6	Хөв цөөрөм	1	5.1	3.7
Дотуур байрны барилга	4	29.4	10.5	Зэсвэгт хүчний ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв	1	3.5	1.6
Сургуулийн барилга	1	26.9	8.1	Их суруулийн цогцолборын гадна тохижилт	1	3.1	1.4
Үерийн хамгаалалтын барилга	4	25.4	9.4	Авто гарааж, засварын барилга	1	3	1.4
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга	3	25	7.4	Бэлчээрийн усан хангамж	1	2.6	2.6
Цахилгаан хангамж	2	21.6	7.1	Гадаадын иргэн харьяатын газрын барилга	1	2.4	1.1
Их сургуулийн барилга	1	21.3	6.4	Цаг уурын харуулын барилга	1	0.4	0.4

Шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөвт өртөг ба санхүүжилтийн дүнгээр авто зам, эмнэлгийн барилга, хурал зохион байгуулахтай холбоотой барилгын төслүүд тэргүүлж байна.



Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ

Нийт төсөвт өртөг: **234.2 тэрбум ₮**



Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл

Нийт төсөвт өртөг: **170.9 тэрбум ₮**



НҮБ-ын суурь конвенцийн 17-р бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж

Нийт төсөвт өртөг: **150 тэрбум ₮**



Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц

Нийт төсөвт өртөг: **108.6 тэрбум ₮**



Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл

Нийт төсөвт өртөг: **106.9 тэрбум ₮**

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн байгууллага, ерөнхий боловсролын сургуульд хамгийн өндөр төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмж худалдан авна.


Зориулалт	Тоо	Төсөвт өртөг (Тэрбум ₮)	2026 онд санхүүжих дүн (Тэрбум ₮)	Зориулалт	Тоо	Төсөвт өртөг (Тэрбум ₮)	2026 онд санхүүжих дүн (Тэрбум ₮)
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт	4	91.8	91.8	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	1	8.4	8.4
Эрүүл мэндийн байгууллага	9	49.7	49.7	Хил хамгаалах салбар	1	8.2	8.2
Ерөнхий боловсролын сургууль	11	48.7	48.7	Сургуулийн өмнөх боловсрол	6	8	8
Батлан хамгаалах салбар	2	36.4	36.4	Төрийн үйлчилгээ	1	7	7
Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лаборатори	1	32.5	32.5	Улсын бүртгэл	1	5.6	5.6
Хууль зүйн салбар	5	29.4	29.4	Төсөв, санхүүгийн цахим систем	1	4.9	4.9
Онцгой байдлын ерөнхий газар	1	29	29	Улсын Их Хурлын Тамгын газар	1	3.6	3.6
Татварын мэдээллийн систем	1	23	23	Үндэсний аудитын газар	1	2.5	2.5
Гадаад харилцааны салбар	1	19.9	19.9	Гаалийн байгууллага	2	2.1	2.1
Төрийн цахим үйлчилгээ	1	19.4	19.4	Шүүхийн байгууллага	3	1.8	1.8
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар	3	15.9	15.9	Авилгатай тэмцэх газар	1	1.5	1.5
Сонгуулийн ерөнхий хороо	1	12.5	12.5	Ерөнхийлөгчийн Тамгын газар	1	0.5	0.5
Стандарт, хэмжил зүйн салбар	1	10.3	10.3	Төрийн албаны зөвлөл	1	0.4	0.4

Зам, тээврийн салбарт хамгийн өндөр төсөвт өртөгтэй их засварын ажил хэрэгжинэ.

Их засвар	Төсөвт өртөг (Тэрбум ₮)	2026 онд санхүүжих дүн (Тэрбум ₮)
Баянтал сумаас Чойр чиглэлийн 24 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар (Говьсүмбэр)	32.2	14.5
Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар (Дорноговь)	22.3	10.0
Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар (Улсын хэмжээнд)	11.0	4.8
Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар (Улаанбаатар)	4.4	4.4
Зэвсэгт хүчний дугаар нэгтгэлийн их засвар, гадна дулааны шугам сүлжээ (Төвийн бүс)	2.9	2.9
Хилийн цэргийн ангийн хилийн салбарын их засвар (Улсын хэмжээнд)	2.6	2.6
Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн барилгын хүчитгэл (УБ, БГД)	1.4	1.4
Цаг уур, орчны шинжилгээний газрын барилгын хүчитгэл (УБ, ЧД)	0.6	0.6
Авлигатай тэмцэх газарын барилгын их засвар (УБ, СБД, 5 дугаар хороо)	0.2	0.2

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацааг Төсвийн тухай хуулийн заалтын дагуу төлөвлөжээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр
шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний дуусах хугацаа




Төсвийн тухай хуулийн 29.3.5-д шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгахаар заасан байдаг.

2026 онд
дуусах
72 төсөл
Нийт
төслийн
48.3%

2027 онд
дуусах
41 төсөл
Нийт
төслийн
27.5%


2028 онд
дуусах
36 төсөл
Нийт
төслийн
24.2%

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гол санхүүжилт Улаанбаатар хотод төвлөрчээ.




Улаанбаатар

Нийт төсөвт өртөг: 850.1 тэрбум ₮ **37.7%**
2026 онд санхүүжих дүн: 489.6 тэрбум ₮ **45.1%**




Улсын хэмжээнд

Нийт төсөвт өртөг: 425.3 тэрбум ₮ **18.8%**
2026 онд санхүүжих дүн: 319.9 тэрбум ₮ **29.5%**



Аймгууд

Нийт төсөвт өртөг: 695.0 тэрбум ₮ **30.8%**
2026 онд санхүүжих дүн: 209.3 тэрбум ₮ **19.3%**



Бүсүүдэд

Нийт төсөвт өртөг: 286.2 тэрбум ₮ **12.7%**
2026 онд санхүүжих дүн: 66.6 тэрбум ₮ **6.1%**

Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр Улаанбаатар хотод шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, дүүрэг

Дүүрэг	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Сонгинохайрхан	3	266.1	31.3%	50.1	10.2%
Нийслэл*	17	236.7	27.8%	180.8	36.9%
Баянзүрх	4	221.9	26.1%	194.4	39.7%
Баянгол	4	54.7	6.4%	21.8	4.5%
Сүхбаатар	8	27.1	3.2%	13.7	2.8%
Чингэлтэй	6	20.6	2.4%	20.6	4.2%
Хан-Уул	3	18.7	2.2%	6.4	1.3%
Багануур	1	4.3	0.5%	1.9	0.4%

*Хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээ

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн хувьд Ховд аймаг тэргүүлж байна.

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Ховд	6	134.3	19.3%	25.2	12.0%
Өмнөговь	1	106.9	15.4%	20	9.6%
Хөвсгөл	7	66.8	9.6%	20.1	9.6%
Дундговь	3	53.4	7.7%	9.4	4.5%
Булган	3	50.4	7.2%	12.5	6.0%
Өвөрхангай	3	42.5	6.1%	25.9	12.4%
Говьсүмбэр	2	38.9	5.6%	16.5	7.9%
Завхан	4	28.6	4.1%	12.9	6.2%
Дорнод	2	26.9	3.9%	7.9	3.8%
Дорноговь	1	22.3	3.2%	10	4.8%
Баян-Өлгий	4	20.5	2.9%	8.2	3.9%
Говь-Алтай	4	17.9	2.6%	6.7	3.2%
Архангай	2	13.5	1.9%	4.5	2.2%
Сүхбаатар	3	13.5	1.9%	6.1	2.9%
Баянхонгор	2	13.2	1.9%	6.1	2.9%
Сэлэнгэ	3	12.5	1.8%	4.6	2.2%
Увс	2	12.3	1.8%	5.6	2.7%
Архангай, Өвөрхангай	1	12.2	1.7%	3.6	1.7%
Төв	1	4.6	0.7%	2.1	1.0%
Дархан-уул	1	3.6	0.5%	1.1	0.5%
Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд	1	0.4	0.10%	0.4	0.20%


Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг ба санхүүжилтийн дүнгээр Зам тээврийн сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нар тэргүүлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Зам, тээврийн сайд	9	464.5	20.60%	108	10.00%
Эрүүл мэндийн сайд	13	328.4	14.60%	105	9.70%
Эрчим хүчний сайд	6	304.7	13.50%	67.9	6.30%
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	8	247.9	11.00%	246.4	22.70%
Боловсролын сайд	32	191.7	8.50%	103.1	9.50%
Хууль зүй, дотоод хэргийн сайд	21	144	6.40%	79.3	7.30%
Батлан хамгаалахын сайд	7	109.1	4.80%	65.8	6.10%
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	2	72.5	3.20%	72.5	6.70%
Монгол Улсын Шадар сайд	7	70.9	3.10%	50.1	4.60%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	11	70.5	3.10%	25.2	2.30%
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	1	41.7	1.90%	12.5	1.20%
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	6	40.4	1.80%	22	2.00%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	6	36.9	1.60%	23.2	2.10%
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	2	33.8	1.50%	23.8	2.20%
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	3	30.7	1.40%	12.1	1.10%
Сангийн сайд	4	30	1.30%	30	2.80%
Гадаад харилцааны сайд	1	19.9	0.90%	19.9	1.80%
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	8.4	0.40%	8.4	0.80%
Монгол Улсын Их Хурлын дарга	1	3.6	0.20%	3.6	0.30%
Монгол Улсын Ерөнхий аудитор	1	2.5	0.10%	2.5	0.20%
Авлигатай тэмцэх газрын дарга	2	1.7	0.10%	1.7	0.20%
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	1	1.5	0.10%	1.5	0.10%
Монгол Улсын Ерөнхийлөгч	1	0.5	0.02%	0.5	0.05%
Төрийн албаны зөвлөлийн дарга	1	0.4	0.02%	0.4	0.04%

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 87.9 хувь нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-д **“Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”** гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ **84.8 их наяд ₮**-ийн төсөвт өртөгтэй, **19 их наяд ₮**-ийн санхүүжих дүнтэй **316** төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.




Улсын хөгжлийн бодлоготой уялдсан

131 төсөл, арга хэмжээ

Нийт төсөвт өртөг: 1941.7 тэрбум ₮

2026 онд санхүүжих дүн: 1008.6 тэрбум ₮



Улсын хөгжлийн бодлоготой уялдаагүй

18 төсөл, арга хэмжээ

Нийт төсөвт өртөг: 315 тэрбум ₮

2026 онд санхүүжих дүн: 76.9 тэрбум ₮

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний бодлогын чиглэл (тэрбум ₮)				
Бодлогын чиглэл	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээнүүд
Бүсчилсэн хөгжлийн бодлого	14	307.5	78.1	Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, стандарт, хэмжил зүйн болон хүнсний лабораторийн тоног төхөөрөмж, Улаанбаатар хот ба аймгууд дахь дулааны станцын хэлхээ, цахилгаан дамжуулах шугам, дулаан хангамж, цэвэр усны сүлжээ, инженерийн шугам шүлжээ, үерийн хамгаалалтын байгууламж ...
Хүний хөгжлийн бодлого	47	557.5	232.5	Улсын хоёрдугаар төв эмнэлэг, хавдар судлал, гэмтэл согог судлалын барилга байгууламжийн өргөтгөл, засвар, анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, эх хүүхдийн эрүүл мэнд, гэмтэл согог, эмгэг судлалын төвүүдийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, их, дээд сургуулийн барилга, дотуур байр, спорт заал, лаборатори, цахим сургалтын орчныг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, соёл, спорт, аялал жуулчлалын салбарын барилга байгууламжийн их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл...
Эдийн засгийн бодлого	21	431.2	357.6	Үр тариа хадгалах агуулах, бэлчээрийн усан хангамж, хөв цөөрөм, НҮБ-ын бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж, тоног төхөөрөмж, гал түймэр унтраах, аврах ангийн барилга, цаг уурын уурын харуулын барилга, радарын систем, Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, цэвэрлэх байгууламж болон Онцгой байдлын ерөнхий газар, Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лаборатори, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн тоног төхөөрөмж...
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	42	412.0	276.1	Төрийн цахим системүүдийн шинэчлэл, хиймэл оюун ухаанд суурилсан платформууд, зэвсэгт хүчний ба хилийн цэргийн ангийн барилга байгууламжийн шинэчлэл, засвар, “112” яаралтай тусламжийн төв, батлан хамгаалахын салбар, шүүх байгууллага, авлига, аудит, гааль, сонгуулийн байгууллагын тоног төхөөрөмжийн төсөл...
Бүсчилсэн хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого	7	233.5	64.3	Авто зам, гүүрийн дэд бүтэц

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдаагүй шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт (тэрбум төгрөг)


№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж (УБ, СБД)	0.5	0.5
2	Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж (УБ, СБД)	3.6	3.6
3	Гадаадын иргэн харьяатын газрын барилга (Баян-Өлгий, Өлгийн сум)	2.4	1.1
4	Цагдаагийн газрын барилга (Булган, Булган сум)	5.4	1.6
5	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга (Говь-Алтай, Ёсөнбулаг сум)	9.2	2.8
6	Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт (Архангай, Эрдэнэбулган сум)	3.1	1.4
7	Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл (Зүүн бүс)	60.2	18.0
8	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас (Хөшигийн хөндий) (Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл (Төвийн бүс)	170.9	25.6
9	Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга (Баян-Өлгий, Өлгий сум)	8.4	3.8
10	Спорт заалны барилга (Ховд, Буянт сум)	3.1	1.4
11	Спорт заалны барилга (Хөвсгөл, Түнхэл сум)	2.2	1.0
12	Спорт цогцолборын барилга (Сэлэнгэ, Сайхан сум)	6.7	2.0
13	Инженерийн шугам сүлжээ (Ховд, Дарви сум)	2.8	1.3
14	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг (Хөвсгөл, Их-Уул сум)	3.7	1.6
15	Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж (Архангай, Эрдэнэбулган сум)	10.4	3.1
16	Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км (Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг)	7.8	3.5
17	Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц (Улсын хэмжээнд)	14.4	4.3
18	Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар (УБ, СБД, 5 дугаар хороо)	0.2	0.2
	Нийт дүн	315.0	76.9

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт, Үндэсний Аудитын Газар


Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 50 хувь нь хуульд заасан санхүүжилтийн шаардлагыг хангахгүй байна.

Төсвийн тухай хуулийн “29.3.5 Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэн заалтын дагуу эхний санхүүжилт буюу 2026 онд санхүүжих дүнг хуулийн дагуу төлөвлөөгүй нийт 75 төсөл, арга хэмжээ байна.

Санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоо



Санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний хувийн жин



Санхүүжилтийн шаардлага хангаагүй, хамгийн өндөр төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнүүд (тэрбум ₮)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	2026 онд санхүүжвэл зохих дүн	2026 онд дутуу төлөвлөсөн санхүүжилт
1	"Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ (УБ, СХД)	2028	234.2	40.5	78.1	37.6
2	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл (Төвийн бүс)	2028	170.9	25.6	57.0	31.3
3	Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 32 хэлхээ 69 км ЦДАШ, 220 /110/ 35 кВ-ын дэд станц (Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сум)	2028	108.6	15.0	36.2	21.2
4	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км (Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум)	2028	106.9	20.0	35.6	15.6
5	Бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж, 2 дугаар үе шат (Улсын хэмжээнд)	2028	78.1	23.4	26.0	2.6
6	Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл (Зүүн бүс)	2028	60.2	18.0	20.1	2.0
7	10 а, б магистраль дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл (Улаанбаатар)	2028	53.7	16.1	17.9	1.8
9	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц (Дундговь, Сайнцагаан сум)	2028	48.0	7.0	16.0	9.0
10	Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)	2028	41.7	12.5	13.9	1.4

ТОЙМ ДҮГНЭЛТ

- Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2.26 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.09 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй, 149 төсөл, арга хэмжээгээр шинээр хэрэгжүүлэхээр тусгасан.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо өмнөх 2025 онтой харьцуулахад 43-аар өсөж, нийт төсөвт өртөг 135 тэрбум төгрөгөөр буурч, тухайн онд санхүүжих дүн 99.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 69.7 хувь барилга байгууламжид, 23.1 хувь тоног төхөөрөмжид, 3.4 хувь их засварт, 2.3 хувь ТЭЗҮ-д, 1.4 хувь цахим системд ногдож байна. Харин нийт санхүүжих дүнгийн 46.7 хувь барилга байгууламжид, 44.4 хувь тоног төхөөрөмжид, 3.8 хувь их засварт, 4 хувь ТЭЗҮ-д, 1.1 хувь цахим системд ногдоно.
- Шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөвт өртөг ба санхүүжилтийн дүнгээр авто зам, эмнэлгийн барилга, хурал зохион байгуулахтай холбоотой барилгын төслүүд тэргүүлж байна.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн байгууллага, ерөнхий боловсролын сургуульд хамгийн өндөр төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмж худалдан авна.
- Зам, тээврийн салбарт хамгийн өндөр төсөвт өртөгтэй их засварын ажил хэрэгжинэ.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацааг төсвийн тухай хуулийн заалтын дагуу төлөвлөжээ.

ТОЙМ ДҮГНЭЛТ

- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гол санхүүжилт Улаанбаатар хотод төвлөрчээ.
- Улаанбаатар хотод шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг ба санхүүжилт дүүргүүдэд харилцан адилгүй байна. Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг ба санхүүжих дүн хамгийн өндөр байна.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг ба санхүүжих дүнгээр Ховд, Өмнөговь, Хөвсгөл аймгууд хамгийн өндөр байгаа бол Төв, Дархан-Уул аймгууд хамгийн бага байна.
- Бүсүүдэд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжилтийн дүнгээр Төвийн бүс тэргүүлж байна.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг ба санхүүжилтийн дүнгээр Зам тээврийн сайд, Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нар тэргүүлж байна.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 87.9 хувь нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна. Харин улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй нийт 315 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 76.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 18 төсөл, арга хэмжээ төлөвлөгджээ. Хүний хөгжлийн бодлоготой уялдсан нийт 557.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 232.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 47 төсөл, арга хэмжээ, Эдийн засгийн бодлоготой уялдсан нийт 431.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 357.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 төсөл, арга хэмжээ, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлоготой уялдсан нийт 412 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 276.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 42 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн. Мөн бүсчилсэн хөгжлийн бодлого ба эдийн засгийн бодлоготой давхар уялдаж буй нийт 233.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 64.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ төлөвлөжээ.
- Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 50 хувь буюу 75 төсөл, арга хэмжээ хуульд заасан санхүүжилтийн шаардлагыг хангахгүй байна. Эдгээр 75 төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжвэл зохих 568.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 409.4 тэрбум төгрөг буюу 158.8 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА